

**“АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2018.02.27

Илтгэгч захирал Б.Шатар

“Адуунчулуун” ХК 2017 онд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, ололт дутагдлынхаа талаар тайлагнаж байна.

Манай компаний хамт олон 2017 онд аймаг орон нутгийн хэрэглэгчдийг өөрсдийнх нь захиалга гэрээний дагуу хэрэгцээт нүүрсээр тасалдуулгүй хангах үндсэн үүргээ ханган биелүүлж ажилласан байна.

Нэг. Үндсэн үйлдвэрлэл

Адуунчулууны нүүрсний ордод 2017 оны уулын ажлын батлагдсан төлөвлөгөөгөөр нүүрс 570.0 мян.тн олборлохоос 510.5 мян.тн буюу 0,895 %, хөрс 1400.0 мян.м³ хуулахаас 1261,9 мян.м³ буюу 0,9 % биелэж, төлөвлөснөөс нүүрс 59.5 мян.тн-р буурч, хөрс 138,1 мян.м³-ээр буурсан байна.

2016 оныхтой харьцуулбал нүүрс олборлолт биет хэмжээгээр 58.4 мян.тн-р буурч, хөрс хуулалт биет хэмжээгээр 254.8 мян.м³-р өссөн үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт	Х/нэгж	2015	2016		2017		
			Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү
Нүүрс олборлолт	мян.тн	469.5	500.0	568.9	570,0	510,5	-59,5
“ДБЭХС” ХК	мян.тн	402.2	430.0	487.6	500,0	424,2	-75,8
Ахуй	мян.тн	67.3	70.0	81.3	70,0	86,3	+16,3
Хөрс хуулалт	мян.м ³	928.5	1400.0	1007.1	1400,0	1261,9	-138,1
Уулын цул	мян.м ³	1323.0	1820.2	1485.2	1970,0	1772,4	-197,6

“ДБЭХС” ТӨХК-д гэрээний дагуу 500.0 мян.тн нүүрс нийлүүлэхээс 424.2 мян.тн-ыг нийлүүлж төлөвлөснөөс 75.8 мян.тн-р багассан, ахуйн хэрэглэгчдэд төлөвлөсний дагуу 70.0 мян.тн нүүрс нийлүүлэхээс 86.3 мян.тн-ыг нийлүүлж төлөвлөснөөс 16.3 мян.тн-р өссөн.

Нийт олборлолтын 83.0%-ийг “ДБЭХС” ХК-д, 17.8%-ийг айл өрх, ААНэгж байгууллагад борлуулсан.

Нүүрс олборлолтын хэмжээ 2015-2016 он хүртэл өссөн үзүүлэлт байсан. 2017 онд 510,5 болж 58,4 мянган тонноор буурсан.

Үүнд “ДБЭХС” ТӨХК-ийн хэрэглээ 2015, 2017 онуудад буурсан, харин айл өрх, ААНэгжүүдийн хэрэглээ нэмэгдсэн харагдаж байна.

Уулын цулын үзүүлэлт өнгөрсөн онд 1485,2.0 мян.м³, төлөвлөгөөгөөр 1970,0 мян.м³ байсан бол тайлант хугацаанд 1772.2 мян.м³ гарч өнгөрсөн оноос 287.0 мян.м³-р өсч, төлөвлөснөөс 197,6.0 мян.м³-р буурсан.


А. Нүүрс олборлолтын ажлын хүрээнд хийгдсэн ажлууд:

Манай хамт олон 2017 оны нүүрс олборлолтын ажлыг 1 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 29-ыг хүртэл 241 хоногийн хугацаанд нүүрсний 3 түвшингээс ЭКГ-4,6Б маркийн №986, ЭКГ-5А маркийн №12273, №10823 экскаваторуудаар “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит

хувьцаат компанид 424233.7 тонн нүүрсийг нийлүүлж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 84,9%-иар биелүүлж ажилласнаас гадна ахуйн борлуулалтанд 86329,4 тонн нүүрс хэрэглэгчдэд шигшиж ачиж, нийт 510563,1 тонн нүүрс олборлосон байна.

“ДБЭХС” ТӨХК нь 2017 онд 500,0 мянган тонн нүүрс худалдан авахаар захиалга өгч, 1-5 дугаар саруудад нэмэгдүүлж /5,0 мянган тонн тус бүр/, мөн 7, 8, 9 дүгээр саруудад Дорнод МАК уурхайгаас туршилтын журмаар нүүрс авч, нүүрсний нийлүүлэлтийг хязгаарласнаас үйлдвэрлэлийн үндсэн төлөвлөгөө биелэгдэхгүй байх гол шалтгаан болсон гэж дүгнэж байна.

Сүүлийн жилүүдэд олборлосон нүүрсний хэмжээ /станц, ахуй/



В. Хөрс хуулалтын ажлын хүрээнд хийгдсэн ажлууд:

Тус хэсгийн хамт олон 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 11 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл 164 хоногийн хугацаанд 1261863.2 м³ хөрс хуулалтын ажил хийж гүйцэтгэлээ.


Энэ хугацаанд хөрс хуулалтын ажлыг уурхайн ажлын хойд бортонд явуулж, хөрсний түвшингүүдэд дундажаар 25-36 метрийн өргөн ахилт хийж, хөрс хуулалтын ажлын төлөвлөгөөг 90,1%-иар биелүүлж ажилласан байна.

Өмнөх оны хөрс хуулалтын ажлын гүйцэтгэлтэй харьцуулахад 254796,0 м³-ээр илүү хөрс хуулж, 11 хоногоор бага хугацаа зарцуулж ажилласан нь ажиллагсдын идэвх зүтгэл сайжирсан, экскаваторын засвар үйлчилгээний чанар сайжирснаас эвдрэл гэмтэл багассан, уулын ажлын удирдлага зохион байгуулалт оновчтой байсан зэрэг олон хүчин зүйлээс хамаарч бидний ажил САЙЖИРСАН гэж хэсгийн зүгээс дүгнэж байна.


Уурхайн хэмжээнд хөрс хуулалтын коэффициент /төлөвлөгдсөн 2,46 м³/тн//



Сүүлийн 4 жилийн хөрс хуулалтын ажлын гүйцэтгэл:



Хөрсний түвшингүүдийн хөрс хуулалтын ажлын гүйцэтгэл:



Хоёр. Их засвар техник зохион байгуулалтын талаар

Үндсэн тоноглолуудад хэсэг цехийн батлагдсан график төлөвлөгөөний дагуу их засварын ажлыг 2017 оны 1 дүгээр сараас 4 дүгээр сарын 20 хүртэлх хугацаанд хийгдсэн байна.

Автозасварын хэсэгт 34 машин механизмд засвар хийж машин бүрийн зардлыг тооцож нийт 692.408.140 төгрөгийн сэлбэг материалын зардал гарсан. (Тайлангийн хавсралтаас үзэх)

Уулын хэсэгт 8 төрлийн уулын машин механизмд 621.615.070 төгрөгийн сэлбэг материалын зардал гарсан байна. (Тайлангийн хавсралтаас үзэх)

2016 онд уурхайн хэмжээнд 575432 литр дизель түлшний орлого авч зарлага нь 577021 литр. Дизель түлшний 1 литр дахь дундаж үнэ 1403 төгрөг байснаар 807,331,096 төгрөгийн зардал гарсан.

2017 онд 544117 литрийн орлого авч нийт зардал нь 588562 литр. 1 литрийн дундаж үнэ 1520 төгрөг байснаар 588562*1520 төг.=894,614,240 төг. зардал гарсан. 2016 оныхоос түлшний зардал 87,283,144 төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь хөрс 178400 м³-ээр нэмэгдсэнтэй холбоотой ба 1 литр түлшний үнэ 117 төгрөг нэмэгдсэнээр түлшний зардал өссөн байна.

Засвар хийгдсэн тоноглолуудаас 2 самосвал 1 бүтэн жил хөрс, нүүрсэнд гараагүй байна. 2 бульдозер засварлагдсан гэх боловч түрэлт бүрэн хийж ажил гүйцэтгээгүй байж 2018 онд засварт

одоо орж байна. Эскаватор-8690-ийн 5 машины агергатад их засвар, ЯКНО-2 ширхэгийг бүрэн засвар, бэлтгэл ЯКНО-той болсон. Эскаваторын 5 машины агергат 2 ком. бэлтгэлтэй болгож складад хадгалан орлогод авсан. Подъёмны хөдөлгүүр 1 ш, напорын хөдөлгүүр 3 ш, явахын хөдөлгүүр 2 ш, поворотын хөдөлгүүр 2 ш бэлтгэлтэй болсон байна. Эскаваторын венец араа 4 ш, подъёмны том араа 5 ш, кремлений шестерн 8 ш, замын кольцо 3 ш шинээр захиалж бэлтгэлд оруулж хөрөнгө оруулалтыг хийсэн. Эскаватор, автосамасвол, ковш, грейдер, бульдозерын их засварыг өөрсдийн хүмүүсээр засварладаг болсон нь манай засварын хамт олны зорилго биелэж цаашид дадлагажилт, ур чадвараа дээшлүүлж амжилтанд хүрэх нөхцөл бүрдсэн гэж дүгнэж байна.

Засварчид нөхөн сэргээх засварын ажлыг улам боловсронгуй болгож, зөв технологи сонгон чанартай гүйцэтгэхэд санаачлагатай ажиллахыг Инженер техникийн ажилчидад үүрэг болгож байна.

Гурав. Компаний хүний нөөц, бүтэц зохион байгуулалтын талаар:

Захирлын 2017 оны 3-р сарын 13-ний өдрийн А/10 тоот тушаалаар удирдлагын бүтцийг 2 хэлтэс, 3 хэсгийн зохион байгуулалттай, 156 ажилтны орон тоотойгоор баталж мөрдүүлж ажилласан. Нийт 61 ажлын байранд 155 хүний орон тоотойгоор ажилласан. Үүнээс:

- Удирдлага-9
- Мэргэжилтэн-1
- ИТА-13
- Ажилтан-4
- Мэргэжлийн ажилтан-91
- Туслах ажилтан-15
- Үйлчилгээний ажилтан-22

Боловсролын түвшингээр авч үзвэл:

- Дээд боловсролтой-31
- Тусгай дунд-10
- Бүрэн дунд-82
- Бүрэн бус дунд-24

Ажилчдын 46.1% буюу 72 нь 35 хүртэлх насны залуучууд байна.

Шагнал, урамшуулал

Төрийн болон Засгийн газар, аймаг, хотын шагнал урамшуулалд ажилчин 21 ахмадыг тодорхойлсноос 54 хүн нь шагнагдсан:

- Тэргүүний уурхайчин – 7 ажилчин, 3 ахмад
- Яамны жуух бичиг – 3 ажилчин
- Уул уурхайн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойн хүндэт тэмдэг -23 ажилчин, 6 ахмад
- Чойбалсан хотын Тэргүүний ажилчин -3 ажилчин, 3 ахмад
- Хотын засаг даргын жуух бичиг-2 ажилчин

Хөдөлмөрийн харилцаа, зөрчил

Монгол улсын хууль тогтоомжууд болон компаний дотоод журам, хамтын гэрээний дагуу үйл ажиллагаагаа явуулж Компаний хэмжээнд шинээр ажилд орсон 22 ажилчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулж тэдэнд байгууллагын дотоод журам болон хөдөлмөрийн хууль тогтоомжийн талаар зөвлөмж, зааварчилгаа өгөгдсөн.

2017 онд компанийн Захирлын нийт 84 тушаал гарсан. Үүнээс 10 нь А буюу үйл ажиллагааны чиглэлтэй тушаал, 74 нь Б буюу боловсон хүчин, хүнтэй холбогдолтой тушаал гарсан.

Хөдөлмөрийн хууль, дотоод журам зөрчсөн 22 хүн 28 удаагийн сахилгын зөрчил гаргасан.

Гаргасан зөрчлийг ангилвал:

- Ажил тасалсан
- Ажлын байраа орхиж явсан, сэлгүүцсэн
- Ажлаас хожимдсон, эрт явсан
- Ажлын байранд архи уусан, ажилдаа согтуу ирсэн
- Ажлын хариуцлага алдсан

Дээрхи зөрчлүүдэд

- Сануулах-5 хүн
- 1 сарын цалин 20% бууруулах- 5 хүн
- 2 сарын цалин 20% бууруулах- 1 хүн
- 3 сарын цалин 20% бууруулах- 13 хүн
- Албан тушаал бууруулах- 1 хүн
- Ажлаас халах -3 хүн

Сахилгын шийтгэлүүдийг ногдууллаа.

Дөрөв. ХАБЭА

Уурхайн үндсэн ажлын байруудаар ХАБЭА-н үзлэг хяналтыг сар бүр тогтмол хийж хяналтын хуудсаар шалгаж үйлдвэрлэлийн гурван хэсгийн удирдлагад засаж залруулах, ажлын байрны нөхцөлийг сайжруулах, дутагдлаа арилгах үүргийг сар бүр өгч байв.

ХАБЭА-г сайжруулах ажлын сарын төлөвлөлт хэсэг бүрд харилцан адилгүй хэрэгжиж ирсэн.

Гамшгаас хамгаалах Уул уурхайн албаны төлөвлөгөөнд тодотгол хийж Зүүн бүс, Дорнод аймгийн Гамшгаас хамгаалах газарт хянуулж батлуулсан. "Аваарь устгах ажлын 2018 оны төлөвлөгөө"-г боловсруулсан.

Автозасварын газар мөн зогсоолын гаражид агааржуулалтыг сайжруулах утаа зайлуулах вентиллятор (Ф800, Ф900, Ф500) тус бүр 2 ширхэгийг захиалан авч угсран ажиллагаанд оруулах ажлыг зохион байгуулсан.

Автозасварын газрын завсарын сувагт аюулгүй гэрэлтүүлэг (36в) сэргээлгэсэн.

Засвар хийхэд зориулсан талбай, явган зорчих хэсгүүдийн хил заагийг тогтоосон анхааруулах зурвас татах ажлыг хийж эхлүүлсэн.

Ажлын явцад гарсан үйлдвэрлэлийн осолд Үйлдвэрлэлийн ослын акт 1 тогтоосон байна.

ХАБЭА –н ажлын 2017 оны төлөвлөгөөний биелэлт 70% -н гүйцэтгэлтэй гарав.

ХАБЭА-н инженерийн Албан шаардлага 2017 онд ахлах маркшейдерт өгсөн ч хугацаандаа хариу ирүүлээгүй байна . Уурхайн технологи ажиллагаа, хөрсний шилжилт гулсалтад тавих хяналтад ахицтай өөрчлөлт ажиглагдаагүй хэвээр.

Компанийн ХАБЭА-н зөвлөлийг нэг хуралдуулж ХАБЭА-н удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай дүрэм журам боловсруулсныг хэлэлцэж компанийн гүйцэтгэх захирал Б.Шатарт танилцуулахад хэрэгжүүлж ажиллах тушаал гаргахаар шийдвэрлэсэн билээ.

ХАБЭА-н Сургалтын талаар:

Тус уурхайн нийт ажилтны ХАБЭА-н 2017 оны хаврын сургалтыг 02 сарын 03 өдөр компанийн хурлын танхимд батлагдсан хөтөлбөрийн дагуу явуулав. ХАБЭА-н сургалтад компанийн 140 ажилтнаас 110 ажилтан оролцож нийт ажилтны хамрагдалт 78,57% -тай байлаа. Сургалтад хамрагдсан байдлыг доорхи хүснэгтэд харуулав.

дд	Нэгж, хэсэг	Ажилтны			Тайлбар
		тоо	оролцоо	хувь	

1	Захиргаа	27	20	74.00
2	Автозасварын хэсэг	46	36	78.26
3	Цахилгаан сантехникийн хэсэг	18	14	77.77
4	Уулын хэсэг	49	40	83.33
	Нийт	140	110	78.57

Өргөх ,зөөх тээвэрлэх машин механизмтай харьцаж ажиллах 23 ажилтныг 6- н чиглэлээр сургах гэрээг “АОКС” ХХК –тай байгуулж шинээр 9 , давтан 14 хүнийг сурган шалгуулан үнэмлэхжүүлсэн байна.

“Адуунчулуун” ХК –д 2017 онд гарсан Үйлдвэрлэлийн осол


Үйлдвэрлэлийн осолд дөхсөн тохиолдолын бүртгэсэн судалгаа.

д/д	ҮО ба ҮОД тохиолдол	тохиолдол өрстөн хүн	АЗХ	УХ	Нийт тохилдол
1.0	Нүдэнд гадны биет орсон	А.Батдөлгөөн Ц.Мөнхоргил Т.Хүдэрмөнх Б.Ганбаатар	1	3	4
2.0	Хальтарсан	О.Алтансүх	0	1	1
3.0	Юманд цохигдсон	С.Батзориг М.Мөнхнасан	1	1	2
4.0	Технологи , ААДүрэм зөрчсөн	78-21 Б-24	0	2	2 (Ж.Насанбаяр Б.Доржпүрэв)
5.0	Автосамосвал мөргөсөн, тулгуур хугарсан	25-61 Дор 78-91До	2	0	2 Ц.Дамдин... Н.Батжаргал
	ҮОДөхсөн тохиолдол		4 (36.36)	7 (63.63)	11
	Үйлдвэрлэлийн осол	Б.Жавхаа	1	0	1

2017 онд гарсан үйлдвэрлэлийн осолд дөхсөн тохиолдлыг өмнөх онтой харьцуулахд 39%-иар буурсан хэдий ч үйлдвэрлэлийн осол адил хэмжээнд буюу нэг гарчээ.

Автозасварын хэсэгт үйлдвэрлэлийн осол гарсан , дараа нь давтагдаж осолд дөхсөн тохиолдол гарсныг судлан бүртгэж холбогдох ажилтнуудад хариуцлага ногдуулав.

Осолд дөхсөн тохиолдолын бүрдэлдэхүүн:



Тав. Байгаль орчин, ТАА

2016 онд Монгол улсын байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2003 оны 12 –р сарын 29 –ны өдрийн тушаалд заасны дагуу “ Уул уурхайн улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал ”– ын дагуу үйл ажиллагаа явууллаа. 2017 онд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 05-р сарын 01-ээс шимт хөрсийг түрж овоолох ажлаар эхэлж овоолого буюу №2-т хэлбэржүүлэлт түрэлт тэгшилгээ хийгдэж овоолгыг 18-20 градусын налуутай болгон хуучин 6.1 га талбайд техникийн / үүнээс 1.4 га талбай нь хуучин техникийн нөхөн сэргээлт хийж байсан талбай ба дахин 4,7-га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн / 3.8 - га агротехникийн боловсруулалт хийн олон наст ургамлын 150 кг холимог үр тариалан. 3.8 га биологийн үүнээс /2.0 га талбай нь хуучин биологийн нөхөн сэргээлт хийж байсан талбай ба дахин олон наст ургамлын үр тарьж ургуулсан, шинээр 1.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн / Нөхөн сэргээлтэнд дагуурын өлөнгө, ерхөг, согоовор, царгас зэрэг олон наст ургамалууд ургаж энэ жилийн байгаль цаг агаарын тааламжгүй халуун нөхцөлд ургамлын гарц 80%-тай. Мөн нэмж хайлаас мод тарьсан. Мөн борооны усанд хөрс эдвэрсэн газрыг дахин сэргээж шимт хөрсөөр хучин олон наст үр тариалсан .Биологийн нөхөн сэргээлтээр ургамалжуулсан ажлын зардал 3294,9 мян. төг Моджуулсан ажлын зардал 920.2 мян. төг Дорнод аймгийн байгаль орчин газар , Дорнод аймгийн мэргэжлийн хяналт газар ,Хэрлэн голын усны сав газар зэрэг төрийн байгуулалгаар “Адуунчулуун” ХК энэ жил хийсэн нөхөн сэргээлтийн ажилаа тайлагнаж 83%-тай үнэлгээ авч ажилласан байна.

Өмнө жил 650 ширхэг чацаргана тарьснаас 70% -тай ургасан. мөчирын тайрч тандал хийж өсөлтийн түрэгсгэх ажил хийсэн. Нөхөн сэргээлтэнд 11756 литр түлш бензин 75 литр зарцуулсан байна.

2017 оны эцсийн байдлаар 702 толгой мал. Шинэ төл :

Үүнээс: Эм хурга 271 толгой

Эр хурга 335 толгой

Эр ишиг 43 толгой

Эм ишиг 22 толгой

Эр тугал 8 толгой

Эм тугал 2 толгой

Эр унага 5 толгой

Эм унага 3 толгой мал.Нийт 689 толгой мал байна.

Үүнээс: Цайны газарт 156 толгой мал

Хорогдол 87 толгой мал

Малчин Б.Пүрэвжав 15 толгой / хонь 12, ямаа 3 /

Б.Батбаяр 20 толгой / хонь 10, ямаа 9 /


Г.Ганзориг 6 толгой / хонь 3 ямаа 3 /

Б.Нацагдорж 37 толгой / хонь 28 ямаа 9 /

С.Баатарчулуун 6 толгой / ямаа 3 хонь 3 / нийт 84 толгой мал .

Бусад зардал 10 толгой мал

Мал /тоо толгой/	2015	2016	2017
	1292	1702	2193



Энэ жилийн хувьд мал өссөн хорогдол бага гарсан байна. Нийт төлийн орлого 25,695,000 төгрөг орлогдуулсан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн тайлбар

Компанийн нийт хөрөнгө тайлант оны эцэст 10229.0 сая төгрөг болж оны эхний үлдэгдлээс 22.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт хөрөнгийн дүнгийн 48.78%-ийг эргэлтийн хөрөнгийн дүн, 51.22%-ийг эргэлтийн бус хөрөнгийн дүн эзэлж байна.

Нийт эргэлтийн хөрөнгийн хэмжээ оны эхний үлдэгдлээс 333.5 сая төгрөгөөр өссөн бөгөөд мөнгөний үлдэгдэл 560.6 сая төгрөгөөр, бараа материалын үлдэгдэл 564.4 сая төгрөгөөр, эргэлтийн сүргийн мал амьтад 31.7 сая төгрөгөөр, бусад авлага 2.5 сая төгрөгөөр тус тус өсч, дансны авлага 825.7 сая төгрөгөөр буурсан.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 248.2 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэлд 686.1 сая төгрөг байгуулсан.

Тайлант оны эцэст компанийн нийт өр төлбөр 237.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхний үлдэгдлээс 34.6 сая төгрөгөөр буурч гарч байна.

Эзэмшигчдийн өмчийн хувьд тайлант хугацаанд 435.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 2016 оны ноогдол ашигт 378.2 сая төгрөг олгосноор тайлант хугацааны эцэст эзэмшигчийн өмчийн дүн 9991.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.

Тайлант онд хамтын гэрээ болон бусад хууль тогтоомжийн дагуу хандив болон буцалтгүй тусламжинд 111.5 сая төгрөгийг зарцуулсан.

Тайлант онд компани улс орон нутгийн төсөвт татвараар 1157.1 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлээр 482.2 сая төгрөг, нийт 1639.3 сая төгрөг төлсөн байна.

2018 онд тавих ЗОРИЛТ:

1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд удирдлагын зүгээс технологийн болон техникийн дотоод журам гарган мөрдөх, түүний биелэлтэд тавих хяналтын арга нэвтрүүлж үр дүнд хүрэх.
2. Ажиллагсдынхаа одоо байгаа ур чадварыг хүн бүрээр дээшлүүлж, ажилтнуудыг идэвхжүүлэх, ажилдаа хандах хандлагыг өөрчлөх, тодорхой үүрэг авхуулж заавал биелүүлэн ажилласнаар үр дүнд хүргэх.
3. Олборлолт, нүүрсний нийлүүлэлтэнд батлагдсан стандартыг мөрдүүлж, бутлаж ангилах технологийг сайжруулж нэвтрүүлэх.